



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/231

Чингис хот

Дотоод аудитын хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.12, 4.13, Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дотоод аудитын үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, түүний дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд явуулсан дотоод аудитын тайланг хэлэлцэх, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаанд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх зорилгоор Дотоод аудитын хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дотоод аудитын хорооны дарга	Ц.Идэрбат	Аймгийн Засаг дарга
Нарийн бичгийн дарга:	Д.Идэрбат	Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор
Гишүүд:	С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Ш.Цамбасүрэн	Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Х.Баярбаатар	Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн орлогын мэргэжилтэн
	Ц.Ганчимэг	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Хараат бус гишүүн:	Ц.Чинзориг	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

2. Дотоод аудитын хороо нь үйл ажиллагаандаа Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр

231011487

2.

тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийг мөрдөж ажиллахыг даалгасугай.

3. Уг захирамж гарсантай холбоотой аймгийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/16 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ